



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/АБ

Булган сум

Хөрөнгө оруулагчдын чуулган зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол улсын Засгийн газрын 2022 оны 419 дүгээр “Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XVII дугаар Хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 17/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хөдөөгийн сэргэлт-Хөрөнгө оруулагчдын чуулган”-ыг Улаанбаатар хотод зохион байгуулахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням), Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т тус тус даалгасугай.

2. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 34,789,600 (гучин дөрвөн сая долоон зуун наян есөн мянга зургаан зуу) төгрөгийг “Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх Нээлттэй Булган” хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны
 40 дугаар сарын 10-ны өдрийн 17/16 дугаар
 захирамжийн хавсралт



“ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ-ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ЧУУЛГАНЫ БЭЛТГЭЛ” ОРОН
 НУТГИЙН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТЫН ТӨСӨВ

д/д	Шаардлагатай зардал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Үнэ /төгрөг/	
				Нэг бүр	Нийт
1	2	3	4	5	6
Хэвлэлийн зардал					
1	Эх бэлтгэл	тоо	1	550,000	550,000
2	Баннер хэвлэх	м ²	20	16,000	320,000
3	Гарын авлага хэвлэх	тоо	500	8,000	4,000,000
4	Хөлтэй самбар хэвлэх	тоо	12	70,000	840,000
5	Энгэрийн тэмдэг хэвлэх	тоо	150	3,000	450,000
	НИЙТ				6,160,000
Өдрийн цай, оройн хоол					
1	Бургер	ширхэг	200	5,000	1,000,000
2	Цай, кофе	ширхэг	200	2,000	400,000
3	Цэвэр ус	ширхэг	160	1,500	240,000
4	Айраг	литр	1200	7,000	8,400,000
5	Хүлээн авалт	тоо	100	100,000	10,000,000
	НИЙТ				20,040,000
Урлагийн арга хэмжээний зардал					
1	Байр	тоо	14	140,000	1,960,000
2	Хоол	тоо	14	30,000	420,000
	НИЙТ				2,380,000
Бусад					
1	Шатахуун АИ92	литр	1980	2520	4,989,600
2	Шатахуун Дизел	литр	300	4060	1,220,000
	Нийт				6,209,600
	НИЙТ				34,789,600